

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

(2014 оны 1 дүгээр сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт



I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2014 оны 1-р сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1284 болж, 2013 оны мөн үеэс 202 хүнээр өсч, өмнөх сарынхаас 24 хүнээр буурав.

Ажилгүйчүүдийн 52,26 хувь буюу 671 нь эмэгтэйчүүд юм. 2014 оны эхний сард 122 ажлын байр захиалгад бүртгэгдсэнээс 5 ажлын байранд иргэд зуучлагдан ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 40,0 хувь буюу 2 нь эмэгтэйчүүд байна.

Зураг I.1

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 1 дүгээр сарын эцсийн байдлаар




Тайлант сард бүртгүүлсэн 120 ажилгүй иргэний 21,67 хувь нь сургууль төгссөн; 7,5 хувь нь өөр газраас шилжин ирсэн; орон тооны цомхтголд орсон; байгууллага татан буугдсан шалтгаанаар тус бүр 5,83 хувь нь; гадаадаас эргэж ирсэн шалтгаанаар 3,33 хувь нь; 0,83 хувь нь

цэргээс халагдсан; бусад шалтгаанаар 55 хувь нь бүртгүүлжээ.

Ажилгүйчүүдийг боловсролын төвшинээр хуваавал 4,05% нь дээд; 14,02% нь тусгай дунд; 37,54% нь мэргэжлийн анхан шатны; 10,20% нь бүрэн дунд; 9,66% нь бүрэн бус дунд боловсролтой; 24,54% нь бага буюу боловсролгүй иргэн байна.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2014 оны 1 дүгээр сарын эцсийн байдлаар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн яамны сар бүрийн мэдээ

*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 1 сард НДШ-ийн орлого 870.2 сая ₮ болж төлөвлөгөө 80.5 хувь биелж, төлөвлөгөөг Борнуур сум биелүүлж, бусад сумд 26.98-4.92 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 38.1 сая ₮ болж төлөвлөгөө 74.6 хувь биелж,

төлөвлөгөөг бүх сумд 28.0-15.9 хувиар тасалдууллаа. Тэтгэвэр, тэтгэмжид 2147.6 сая ₮ зарцуулж, 100.1 хувь олгов. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 79.7 хувийг өндөр настны; 9.9 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн; 4.2 хувийг тэжээгчээ алдсаны; 6.0 хувийг цэргийн тэтгэвэрт тус тус зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 206581 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 20,9% хувийг орлогоороо бүрдүүлсэн. Сан тус бүрийн орлого зарлагын харьцааг үзүүлбэл тэтгэврийн даатгалын сангийн 15.2%; тэтгэмжийн даатгалын сангийн 41.2%; эрүүл мэндийн даатгалын сангийн 44.6%; үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 121.7%; ажилгүйдлийн даатгалын сангийн 252.3%-ийг тус бүр бүрдүүлжээ.

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2014 оны эхний 1 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 39018 хүнд олгож, 891.9 сая ₮-ийг зарцуулж 2013 оны мөн үеэс хүний тоо 3.7 дахин 30880 хүнээр, зарцуулсан мөнгөний хэмжээ 4.4 дахин 727.9 сая ₮-өөр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 68730 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 68.72 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 17.61 хувийг халамжийн тэтгэвэр; 3.97 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 5.04 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 2.00 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 1.64 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд

нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж; 1.01 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.




I.3 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2014 оны 1 дүгээр сард 131 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 131 болон өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 36 буюу 37,9 хувиар, амьд төрсөн хүүхдийн тоо 39,4 хувиар тус тус өссөн байна.

Зураг I.3

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



Аймгийн хэмжээгээр 2014 оны 1 дүгээр сард нялхасын эндэгдэл гараагүй ба өмнөх онд Жаргалант суманд нялхасын эндэгдэл 1 бүртгэгдэж байжээ. 5 хүртлэх насандаа эндсэн хүүхэд байхгүй байна.

1000 амьд төрөлтөд ногдох нялхасын эндэгдэл 2014 оны 1 дүгээр сард 0 болсон бол өмнөх оны мөн үед 10,0 байжээ.

Зураг I.4


Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



2014 оны эхний 1 сард нийт гарсан халдварт өвчнөөр 25 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 2.6 дахин буюу 67 хүнээр буурлаа. 2013 оны мөн үеэс гахай хавдар 10 дахин; салхинцэцэг 5 дахин; тэмбүү 2,6 дахин; заг хүйтэн 2 дахин; трихомениаз 2 дахин; сүрьеэ 1.4 дахин тус бүр буурчээ. 10000 хүнд ногдох өвчлөл аймгийн дундаж 3 байгаа бол: Сүмбэр 11, Зуунмод 10, Архуст 8 ногдлоо.

Зураг 1.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



1.4 Байгаль орчин

Цаг агаарын тойм, агаарын бохирдол

Агаарын дундаж температур 13-24 градус хүйтэн буюу Дэлгэрхаан орчмоор хүйтний эрч сулавтар, Алтанбулаг орчмоор хүйтэн байв. Өдөр ажиглагдсан агаарын хамгийн дулаан температур нь 3 градус дулаанаас 4 градус хүйтэн буюу Өндөрширээт орчмоор 3 градус дулаан, нутгийн зүүн хойд хэсэг буюу Мөнгөнморьт орчмоор 4 градус хүйтэн байв. Шөнийн хугацааны агаарын хамгийн бага температур нь -30-41 градус хүйтэн буюу Заамар, Дэлгэрхаан, Баянжаргалан орчмоор -30 градус, Алтанбулагт -41 градус хүрч хүйтэрсэн байна. Бүх нутгаар сарын нийлбэр хур тунадас 0,0-3,9 мм, үүнээс хамгийн их нь Борнуурт 3,9 мм,

Батсүмбэрт 3,3 мм цас оржээ. Салхины их хурд нийт нутгаар 6-16 м/с, зарим газраар түр зуур 17-18 м/с хүрлээ.

Төв аймгийн Зуунмод хотын агаарын бохирдлын хэмжилт.

Зуунмод сумын агаарын бохирдол нь 2014 оны 1-р сард 2013 оныхоос, NO₂ ын агууламж багассан үзүүлэлт харагдлаа. Гэвч зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн тохиолдол гараагүй.

2014 оны 2 дугаар сарын цаг агаарын урьдчилсан төлөв.

Төв аймгийн нутгаар. Энэ сарын агаарын температурын дундаж нь 15-20 градус хүйтэн буюу ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй. Хүйтрэх үе Нэг ба гуравдугаар арав хоногийн эхний хагас, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар хүйтний эрч чангарч голын хөндийгөөр шөнөдөө 31-36, өдөртөө 17-22 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 23-28, өдөртөө 13-18 градус хүйтэн. Хүйтний эрч нилээд сулрах үе Нэг ба гуравдугаар арав хоногийн сүүлчээр томоохон голын хөндийгөөр шөнөдөө 19-24, өдөртөө 6-11 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 14-19, өдөртөө 1-6 градус хүйтэн. Бусад хугацаанд Томоохон голын хөндийгөөр шөнөдөө 23-28, өдөртөө 10-15 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 18-23, өдөртөө 6-11 градус хүйтэн. Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Төв аймгийн баруун өмнөд болон зүүн хойд хэсгээр олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар олон жилийн дунджаас ахиу орох төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн эхэн болон нэг ба гуравдугаар арав хоногийн дунд үеэр

нутгийн хойд хэсгээр бага зэргийн цас орно. Хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр ихэнх нутгаар, гуравдугаар арав хоногийн эхээр зарим газраар цас орно. Энэ үеүдэд зарим нутгаар салхи баруун хойноос 12-14 м/с, ялангуяа хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлч, гуравдугаар арав хоногийн эхээр нутгийн өмнөд хэсгээр 16-18 м/с хүртэл ширүүсч цасан болон шороон шуурга шуурах төлөвтэй.




I.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 1 сард аймгийн хэмжээнд 95 гэмт хэрэг бүртгэгдэж 58 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 106.3 сая төгрөгийн хохирол учирлаа.

Зураг I.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар



Зураг I.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 1 дүгээр байдлаар



Гарсан гэмт хэргийн 43.16 хувь нь хулгай; 29.47 хувь нь иргэний эрүүл мэнд, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг; 12.63 хувь нь бусад хэрэг; 9,47 хувь нь замын осол; 4.21 хувь нь танхай дээрэм; 1.05 хувь нь хүний амийн хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Баяндэлгэр, Цээл, Дэлгэрхаан, Аргалант сумдад 10000 хүнд 38-26 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (11) харьцангуй их байна.

Зураг I.10

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр



Гэмт хэргийн тоо 2013 оны мөн үеэс 45 хэргээр өслөө. Зуунмод суманд 1 эмэгтэй 106 эрэгтэй нийт 107 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2013 оны мөн үеэс 54 хүнээр өслөө.

II. Эдийн засгийн үзүүлэлт




II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хадгаламж, Хас банкны салбаруудын дүнгээр 2014 оны эхний 1 сард кассын орлого 57476.1 сая ₮, кассын зарлага 57547.8 сая ₮ болж, гүйлгээнд 1901.1 сая ₮ байна.

Зураг II.1

Хадгаламжийн үлдэгдэлд банкны салбаруудын эзлэх хувийн жин /хувиар/



ХААН, Хадгаламж, Хас банкны салбарууд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад жижиг худалдаа, үйлдвэрлэлийг дэмжих үүднээс бичил бизнес болон нийт олгосон зээлийн үлдэгдэл 1 сарын 31-ний байдлаар 95819.0 сая ₮, байгаа нь өмнөх оны эцсээс 4419.2 сая ₮-өөр өслөө.

Зураг II.2

Зээлийн өрийн үлдэгдэлд банкнуудын салбарын эзлэх хувийн жин, хувиар



2014 он гарсаар Засгийн газраас бичил бизнесийг дэмжих ажлын хүрээнд зээлдэгч нарт 13210.0 сая ₮-ийн зээл олгожээ.

ХААН, Төрийн, Хас банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.19-1.34 хувь, хугацаатай доод хүү 0.62-0.65 хувь, хугацаагүй хадгаламжийн хүү 0.60-0.62 хувьтай байна.



II.2 Төсөв, мөнгө


Төсвийн орлого 2014 оны эхний 1 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 902.5 сая, зарлага 5039.0 сая ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын

төлөвлөгөө 176.89 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас хувь хүний орлогын албан татвар, орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй орлого, газрын төлбөр, төсөвт газрын өөрийн орлогын төлөвлөгөө биелэгдсэнгүй. Аймагийн төсвийн орлого 2013 оны мөн үеэс 51.5 хувь буюу 306.8 сая ₮-өөр буурлаа. Аймагийн төсвийн орлогын 90.65 хувийг татварын, 9.34 хувийг татварын бус, 0.01 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2013 оны мөн үеэс татварын орлого 7.7 нэгжээр өсч, татварын бус орлого 6.5 нэгжээр, хөрөнгө борлуулсны орлого 0.1 нэгжээр тус бүр буурлаа.

Аймагийн нийт 3 шатны орлого 986.8 сая ₮ болж аймагийнх 828.0 сая ₮ буюу 83.91 хувь, сумынх 74.6 сая ₮ буюу 7.56 хувь, улсынх 84.2 сая ₮ буюу 8.54 хувийг тус бүр бүрдүүлжээ.

Зураг II.3


Аймагийн нийт орлогод 3 шатны орлого сая төгрөгөөр



2013 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 9.45 хувь буюу 27.6 сая ₮-өөр өсч 319.8 сая ₮, авлага 7.54 хувь буюу 8.2 сая ₮-өөр буурч 100.7 сая ₮ боллоо. Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 828.0 сая ₮ болж 173.45 хувь биелж,

Жаргалант, Алтанбулаг, Эрдэнэ, Баян-Өнжүүл, Эрдэнэсант, Борнуур, Батсүмбэр, Баян, Баянхангай, Бүрэн, Өндөрширээт, Лүн, Сүмбэр, Угтаал, Мөнгөнморьт, Баянцагаан, Баянжаргалан, Зуунмод, сумд 73.7-2.3 хувиар тасалдууллаа.

Зураг II.3
Төсвийн зарлагын бүтэц салбараар, 2014 оны 1 дүгээр сарын байдлаар, хувиар




II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Аймгийн төвд 2014 оны 1-р сард ХҮИ /хэрэглээний үнийн индекс/ суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 41,29%, өмнөх оны мөн үеэс 13,22%, өмнөх сараас 1,97 хувиар тус тус өсөв.

1-р сард өмнөх сартай харьцуулахад нийт өрхийн хүнсний хэрэглээнд өндөр хувийн жин эзэлдэг сүү сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 10,48%; мах махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 6,49%; хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 5,39%; талх, гурил, будааны дэд бүлгийн үнэ 1,60%; хүнсний бусад бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 1,40%; согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 0,93%; саахар, жимсний чанамал, зөгийн бал, чихэр шоколадны дэд бүлгийн үнэ 0,1%-аар тус тус өсч, төрөл бүрийн өөх

тосны дэд бүлгийн үнэ 1,71%, жимс жимсгэний дэд бүлгийн үнэ 1,4%-аар тус тус буурав.

Зураг II.4
Хэрэглээний үнийн аймгийн индекс (өмнөх оны 12 сар=100)



Хэрэглээний үнийн индексийн 2014 оны 1 дүгээр сарын 1,97 хувийн өсөлтийн 0,75 нэгж (38.3%) нь хүнсний барааны бүлгийн үнийн өсөлтөөс; 0,51 нэгж (25,7%) нь орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн; 0,42 нэгж (21.4%) нь гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн; 0,13 нэгж (6,8%) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн; 0,07 нэгж (3,9%) нь согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлгийн; 0,04 нэгж (2,3%) нь тээврийн бүлгийн; 0,03 нэгж (1.6%) нь бусад бараа үйлчилгээний бүлгийн үнийн өөрчлөлтөөс тус тус шалтгаалсан байна.

Зураг II. 5

Инфляцийн өсөлтөд үзүүлсэн бүлгүүдийн нөлөөлөл

Бараа, үйлчилгээний бүлэг	2014 оны 1 сард	
	пунктээр	хувиар
Бүгд	1.97	100.0%
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	0.76	38.3%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.08	3.9%
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.13	6.8%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.51	25.7%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.42	21.4%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.0%
07. ТЭЭВЭР	0.05	2.3%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.0%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.0%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.0%
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.0%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.03	1.6%

Мал аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний үнийн судалгаагаар 2014 оны 1 дүгээр сард үхрийн 2 м-ээс дээш урттай ширнийн дундаж үнэ Сүмбэр, Дэлгэрхаан, Аргалант, Баян, Баянцагаан, Баянцогт сумдад хамгийн бага буюу 15,0-25,0 мян.төг, Эрдэнэ, Баянхангай, Баянчандмань, Борнуур, Батсүмбэр, Цээл, Зуунмод сумдад хамгийн их буюу 50,0-45,0 мян.төг байна. Адууны ширний үнэ Сүмбэр, Баяндэлгэр, Баянцагаан, Цээл сумдад хамгийн бага буюу 20,0-26,0 мян.төг, Сэргэлэн, Аргалант, Баянчандмань, Заамар, Эрдэнэ, Эрдэнэсант сумдад хамгийн их буюу 45,0-35,0 мян.төг байна.




II.4 Хөдөө аж ахуй

2014 оны 2 сарын 1-ний байдлаар оны эхний малын 0.03 хувь буюу 1128 том мал зүй бусаар хорогдсон нь 2013 оны мөн үеэс 2.1 дахин буюу 2376 толгойгоор; 2005-2013 оны мөн үеүдийн дунджаас 5.1 дахин буюу 5793 толгойгоор тус бүр буурлаа.

Зураг II.6

Хорогдсон том малын хувийн жин - төрлөөр



Хамгийн их хорогдолтой 5 сум Сүмбэр, Баян-Өнжүүл, Батсүмбэр, Баянцогт, Мөнгөнморьт сумд оны эхний малынхаа 0.47-0.05 хувь буюу 654-30 том мал зүй бусаар хорогдуулсан нь аймгийн бүх

хорогдолын 86.25 хувь (бүгд 973) эзлэв. Оны эхний адууны 0.04, үхрийн 0.03, хонины 0.03; ямааны 0.04 хувь нь тус бүр хорогдов. Бүх зүй бусаар хорогдсон малын 8.33 хувь нь өвчнөөр, 25.44 хувь нь хээлтэгч мал эзлэв.



II.5 Аж үйлдвэр

2014 оны эхний 1 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 911.74 сая ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2013 оны мөн үеэс 97.3 хувь буюу 449.71 сая ₮-өөр өслөө.

Зураг II.7

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр

Аж үйлдвэрийн салбар	2012 I	2013 I	2014 I	2014 I / 2013 I	%
Нийт дүн	326.96	462.03	911.74	197.3%	
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	6.78	12.5	3.5	28.0%	
Боловсруулах аж үйлдвэр	60.41	187.18	682.79	364.8%	
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	259.77	262.35	225.45	85.9%	

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн архи, ундаа үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэл, хувцас үйлдвэрлэл, арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, мод, модон эдлэлийн үйлдвэрлэл 2013 оны мөн үеэс 182.4-44.6 хувь буюу 222.5-6.94 сая ₮-өөр өссөн нь нөлөөлөв.

Оны эхний 1 сарын нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 24.73, боловсруулах үйлдвэрлэл 74.89, уул уурхайн үйлдвэрлэл 0.38 хувийг тус тус эзлэв.

Зураг II.8
 Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр




Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Зуунмод, Баянцогт, Батсүмбэр, Эрдэнэсант, Эрдэнэ, Алтанбулаг сумд 60.44-1.79 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 81.40) хувийг эзлэв.

Зураг II.9
 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, хувиар



орлогын 43.76 хувийг албан бичгийн, 24.71 хувийг зорчигчдын, 31.53 хувийг бусад орлого эзлэв.

Зураг II.10
 Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр



III.6 Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 1 сард 23.1 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 11,9 сая ₮ болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 дахин буюу 13,3 сая ₮-өөр өслөө. Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 4,7 сая ₮ болж, нийт орлогын 56 хувь нь хүн амд үйлчилсэний орлого байна. Нийт